



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.04.24 № ХБ-134-12/4963
танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу өгөх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240101799 дугаартай “Төмөр замын 10, 29 дүгээр замын их засварын ажил”-ын тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ирүүлсэн тодруулгын хариут хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт *д.* хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА



П.БАТБОЛОР

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407018971

1. Сайн байна уу? Боловсролын ерөнхий газар "Политехникум болон коллеж төгссөн хүмүүсийн бичиг баримтыг одоогоор хүлээж авахгүй. Программ нь засвартай байгаа. Тендерт дипломоо цаасаар илгээж болно" гэж байна. Төмөр замын коллеж төгссөн хүний дипломыг тендерт хавсаргаж илгээж болох уу?

Хариулт: Болно.

2. Сайн байна уу? Дэр модыг ямар хэмжээтэйгээр тайрч богиносгох вэ. Засвар хийх зам нь өндөрлөсөн зам бол уг замын өндөр, өргөний хэмжээг өгнө үү?

Хариулт:

"КОМБИНАТ" өртөөний салаа зам № 10

Үе №	Зам төмрийн хэмжээ /м/		Дэрийн төрөл /ш/		Засах гэмтэл	Бусад тон/төх
	Б	З	Мод	Т/Б 2.5 м		
6	12.5	12.5	20		200 дэр модыг 2.5 м урттай төмөр бетон дэрээр солих, Р43 маркийн зам төмрийг Р50 маркийн зам төмрөөр солих, дэр хоорондын бетон хэсгийг хуулж шинэчлэн бетондох, 9-р үен дээр байрлах 3.5 урттай автогармыг 5 м болгон уртасгах, гармын дор байрлах шалавч 10 ш модон дэртэй байна	гарам 3.5 м
7	12.5	12.5	19			
8	12.5	12.5	20			
9	12.5	12.5	20			
10	12.5	12.5	19			
11	12.5	12.5	19			
12	12.5	12.5	19			
13	12.5	12.5	20			
14	12.5	12.5	19			
15	10.38	12.5	16			
16	12.02	12.5	18			
	134.9	137.5	209	0		

Стандарт төмөр бетон дэрний урт 2.70 м байдаг.

"КОМБИНАТ" өртөөний салаа зам № 29

Үе №	Зам төмрийн хэмжээ /м/		Модон дэрийн тоо	Дэрийн задаргаа /м/				Анкер боолт	Замын байдал	Засах гэмтэл	
	Б	З		0.6	2.12	2.35	2.75				
8	12.5	12.5	23	24	8		3	92	1 дэрэнд 4 боолттой	бункертэй	Зүүн жирээ зам төмрийн гагнаатай, баруун зүүн жирээ балбайлттай, 44 гэмтэлтэй. 1958 оны зам төмөртэй, Р50 зам
9	12.5	12.5	26	4	24			104		бункертэй	
10	12.5	12.5	31		31			124		бункертэй	
11	12.5	12.5	32		32			128		бункертэй	
12	25	25	38			18	20		боолтгүй	бункергүй	
13	25	25	40				40		боолтгүй	бункергүй	

											төмрөөр солих, модон дэрүүдийг солих
	100	100	190	28	95	18	63	448			

Өндөрлөсөн тавцангүй

3. Сайн байна уу? Төрийн худалдан авах цахим системд Зам тээврийн хөгжлийн яамны олгосон нэг ч тусгай зөвшөөрөл бүртгэгдээгүй байгаа тул цаасаар тендерийн материалд хавсаргаж оруул гэж төрийн худалдан авах ажиллагааны цахим систем хариуцсан ажилтан мэдэгдсэн. Иймд тусгай зөвшөөрлийг цаасан хэлбэрээр тендерийн материалд хавсаргаж болох уу?

Хариулт: Болно.

4. Сайн байна уу? ТШЗ-ын 19.2.1-д Төмөр замын инженер буюу техникч 1 хүн, ХАБЭА-ын инженер 1 хүн гэсэн байна. Манай компани нь хүний нөөцийн тооноос хамаарч Ерөнхий инженер нь ХАБЭА-ын сертификаттай, байгууллагын ХАБЭА-ыг хавсарч гүйцэтгэдэг. Замын техникч нь тусдаа хариуцсан ажлаа гүйцэтгэдэг. Ийм учраас ХАБЭА-ын инженерийг Замын инженер хавсарч бичиг баримтыг нь илгээж, харин Замын техникчийг тусд нь илгээж болох уу. Хүний тоонд өөрчлөлт ороогүй болно.

Хариулт: Болно.